



“ЖАРГАЛАНТ УС ДТС” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 01/01

Жаргалант сум

“Жаргалант-Ус ДТС” ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.4, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Жаргалант-Ус ДТС” ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн сонгосугай. Үүнд:

Б.Ганзориг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Б.Золоо	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга
Л.Галсансайнхувьт	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Ц.Ганбаяр	Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга
Б.Баттөр	Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн
Г.Тулгабаатар	Хотын захирагчийн албаны Барилгын инженер, ахлах мэргэжилтэн
Ц.Одбаяр	“Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн Дулааны инженер
Ё. Пэрэнлиймаа	Орхон аймаг, Баян-Өндөр сумын иргэн
Д.Нармандах	“ХОЛЛ” ХХК-ийн Санхүүгийн зөвлөх

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХБАТ



Албан хэрэгцээнд
6125000003